



ДАРХАН-УУЛ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 31 өдөр

Дугаар 01-Б/39

Дархан

Даваасамбуугийн Батбаярыг ажилд
томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, 101 дүгээр зүйлийн 101.1, Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.2.5, “Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар” ОНӨААТҮГ-ын дүрэм, батлагдсан төлөвлөгөөг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Авлигатай тэмцэх газрын 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 05/17314 дугаартай албан бичигт Даваасамбуугийн Батбаярыг “Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар” ОНӨААТҮГ-ын даргын албан тушаалд томилоход ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй байх тул 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн томилсугай.

2.Ажил хүлээлцэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ахлагч:

П.Батсүх

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө
оруулалтын хэлтсийн дарга)

Гишүүд:

Д.Бат-Эрдэнэ

(Орон нутгийн өмчийн газрын дарга)

У.Заяахүү

(“Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн
газар” ОНӨААТҮГ-ын ерөнхий инженер)

С.Нарангарав

(“Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн
газар” ОНӨААТҮГ-ын нягтлан бодогч)

3.Үүрэгт ажлыг 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор хүлээлцүүлж, дүнг тайлагнахыг ажлын хэсэг (П.Батсүх)-т үүрэг болгосугай.

4.Д.Батбаярын сарын цалинг 3,500,000 (гурван сая таван зуун мянга) төгрөгөөр тогтоож, холбогдох нэмэгдэл, урамшууллыг хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу олгохыг “Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар” ОНӨААТҮГ-ын нягтлан бодогч (С.Нарангарав)-д зөвшөөрсүгэй.

5. Албан тушаалын хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг 30 хоногийн дотор эрх бүхий албан тушаалтанд мэдүүлэхийг Д.Батбаярт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АЗЖАРГАЛ